

2020 ОНЫ АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
БОЛОН ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ
ДААН НЭР ДЭВШИГЧ ЦЭВЭЭН ОВОГТОЙ ЛУВСАНЛХАМОГИЙН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР


Уриа: ХОВДОО САЙХАН АМЬДАРЦГААЯ 2020-2024

Хөтөлбөрийн зорилго:

Ховдчууд бид оюуны өндөр чадамжтай алсын хараатай хөдөлмөрч, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж ирсэн ард түмэн билээ. Сүрлэг Уулсынхаа дунд авшиг ерөөл шингэсэн газар нутагтай, арвин их газрын нөөц баялагтай, үүх түүх соёл уламжлал нь өвлөгдөн ирсэн олон ясны өлгий нутаг. Тийм болохоор аль ч улс орны ард түмнээс илүү амар тайван, эрүүл саруул, сайхан амьдарч, хойч үедээ баталгаатай ирээдүй, зөв шударга тогтолцоо, ахмад буурлууддаа дутагдах зүйлгүй амгалан аж төрөх орчин бий болгох ёстой. Ховдын ард түмэн төрдөө итгэх итгэлээ сэргээхийн тулд тогтвортойгоор засаглаж чадах бүлэг фракцад хуваагдахгүй эвлэлдэн нэгдэх чадвартай олигархуудын эрх ашигт барьцаалагдаагүй ард түмнийхээ зовлон жаргалыг мэддэг нутаг орондоо амьдардаг, тэднийхээ төлөө ажиллах чин хүсэл эрмэлзэлтэй ёс суртахуунтай улс төрийн төлөөлөлтэй болохыг хүлээж байна.

Тиймээс миний бие Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулиар та бүхнийхээ дэмжлэгтэйгээр аймаг орон нутагтаа хийж хэрэгжүүлэх бодлогоо тусгасан “Ховддоо сайхан амьдарцгаая 2020-2024” мөрийн хөтөлбөрөө танилцуулж байна.

1. Шударга ёсыг тогтоож, уламжлал ёс заншилаа дээдэлнэ.
 - Төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагч бүхэнд иргэдийн эрх ашиг нэгдүгээрт байх хүнд сурталгүй, ард иргэдээ гэсэн сэтгэлтэй, мэдлэг чадвартай, түргэн шуурхай, авлига, хээл хахуулгүй нутгийн өөрөө удирдах байгууллагыг бүрдүүлэн хамтран ажиллана
 - Хууль гажуудуулж, хуулийг уландаа гишгэсэн төрийн түшээдэд хариуцлага нэхэхийг шаардаж ажиллана.
 - Аливаа төсөл тендэрийн шалгаруулалт, бараа үйлчлэгээ худалдан авах, шалгаруулалт, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд очих зээлийн журмыг сайжруулах, журмын дагуу шударга олгогдож байгаа эсэх, хэрэгжилтэнд хяналт тавих, зүй бус ашигласан хамаарал бүхий ААН-ээрээ дамжуулан тендэр авсан ашиг сонирхолын зөрчилтэй дарга нарт ард иргэдийнхээ өмнөөс хариуцлага тооцуулахыг шаардаж ажиллана.



- Гэмт хэрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулна.
- Төрийн албаны шалгалт, ажлын байрны сул орон тоог нөхөж ажилд авах үед мэргэшлийн их дээд сургууль төгссөн иргэдийг шударга шалгаруулж авах процессыг хянах мэргэшсэн төрийн албан хаагдыг хоморголон халах явдалд ард түмний дуу хоолой болж тэмцэх болно.

2. Эдийн засгийн бодлогын хүрээнд:

- Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн зээлийг олон нийтэд ил тод нээлттэй болгож жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал дээр анхаарч ажиллах
- Өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжиж төртөй холбох, авлига хээл хахуулгүй бизнесийн салбарыг орон нутагтаа бий болгох

3. Нийгмийн хөгжлийг дараах гол салбаруудад чиглүүлнэ.


➤ Боловсрол :

- Хүүхдийн СӨБ-ын хамралдалтыг нэмэгдүүлэнэ
- Зуны цэцэрлэг, сувилал хөдөлмөр зусланг сэргээн хөгжүүлэх
- Сурагчдын чөлөөт цаг өнгөрөөх секц дугуйлан, фитнес клубуудыг нэмэгдүүлэх, дэмжин ажиллана
- Багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах, дэмжих
- Оюутан залуучуудынхаа боловсролыг дэмжих, их дээд сургууль төгссөн залуусыг төрийн албанд намын харъялал хамаарахгүй боловсрол чадвараас нь ажилд авдаг болж, мерит тогтолцоог баримтлахад анхаарах
- Ховд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Ховд их сургууль, Политехник коллеж –д сурч байгаа болон төгсөгчдийг ажлын байраар хангасан ААН-ийг төрийн бодлогоор дэмжихийг анхаарах

- Соёл урлаг:

➤ Эрүүл мэнд

- Нярай хүүхдийн шарлагын аппарат болон бусад шаардлагатай эмнэлэгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх хүчин чадлыг сайжруулахад анхаарах
- Багийн өрхийн эмнэлэгт шүдний өвчлөл бууруулах хөтөлбөр санаачилж өрхийн эмнэлэгтээ багийн иргэд шүдээ үзүүлж эмчлүүлдэг болгох
- Багийн нийт иргэдээ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж үзлэгийг иргэддээ тогтмол шат дараатайгаар зохион байгуулдаг үзлэг шинжилгээнд хамруулдаг болгох
- Өсвөр үе залуучуудын нөхөн үржихүй, БЗХӨ –нөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Зуны сувилал чийрэгжүүлэлтэнд хамрагдах 0-5 насны хамрагдалт, чанар хүртээмжийг сайжруулах, төрийн бодлогоор дэмжин ажиллах



➤ Нийгмийн халамж

- Өрх толгойлсон эцэг эх, хагас бүтэн өнчин хүүхдүүд, өрхийн амьжиргааны түвшин доогуур ажилгүй орлогогүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ нийгмийн асуудалд анхаарч холбогдох газруудад уламжилж ажиллана.
- Ахмадын төвтөй болгох асуудлыг шийдүүлж чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөлөөр хангана

➤ Биеийн тамир спорт аялал жуулчлал

- Иргэдийнхээ эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх зорилгоор Нийтийн биеийн тамирын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хөдөлгөөний дутагдалаас урьдчилан сэргийлэх спорт өдөрлөгүүдийг зохион байгуулдаг болох
- Спортын холбоодуудтай хамтарч дугуйн аялал, эко байгалийн үзэсгэлэн аялал, үндэсний спорт шагайн харваа, сурын харваа зэргийг түлхүү хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх


4. Байгаль орчин

- Байгаль орчин экологийн тэнцвэрийг хадгалж ногоон орчныг бүрдүүлэн хамгаалалт арчлалтыг сайжруулах, ургасан мод бутаа услах услалтын систем суваг шуудууг татуулах
- Гудамж талбайн хогийг багийн даргын санаачлагаар нийгмийн ажилтан иргэдтэйгээ хамтран тогтмол цэвэрлэгээ хийлгэж хогийн цэгт хүргүүлдэг байх цэвэр цэмцгэр байгальд ээлтэй эко баг болгох

5. Дэд бүтэц, Барилга хот байгуулалтын хүрээнд

- Иргэд аж ахуйн нэгжүүдэд газар олголтын ажлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж уламжлах
- Олон гудамж дамжиж тог цахилгаан авдаг айл өрхүүдийн асуудлуудыг шийдвэрлүүлэх холбох ажлыг санаачилна
- Гэр хорооллын гудамжинд гэрэлтүүлэг, явган хүний замыг нэмж тавиулах
- Буянт багтаа бохир цэвэр, халаалтын шугамуудыг оруулах, хаус хороолол байрыг хувийн хэвшилүүдтэй хамтарч нэмж бий болгоно.
- Шинээр баригдаж буй Орон сууцнуудын гадна тохижилт, гадаад өнгө үзэмжийг бүрэн гүйцэд хийлгэж хүлээж авах тал дээр шаардлага тавьж ажиллана.

6. Хөдөө аж ахуй, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд :



- Газар тариалан эрхлэлтийг түлхүү дэмжиж иргэддээ хүлэмж , цаашид хүлэмжийн аж ахуй эрхлэх боломжыг нэмэгдүүлж хөгжүүлэх тал дээр нь бодитоор дэмжинэ
- Багийнхаа төвд сүү цагаан идээ борлуулж багийн иргэддээ үйлчлэх цагаан идээгээр иргэдээ хангах төв байгуулах
- Нам даралтын зуухнуудыг буулгуулж халаалтын нэгдсэн системд холбуулах ажлын зохион байгуулан ажиллах болно.

